



БОЛОРЖОНШ ХХК



**“БОЛОР ЖОНШ” ХХК-ИЙ ЗҮҮН АРГАТАЙ
УУРХАЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 он



Агуулга

1	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
1.1	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр.....	5
1.1.1	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:	5
1.1.2	Төслийн нэр	5
1.1.3	Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг:	5
1.1.4	Захирлын нэр, утас:.....	5
1.1.5	Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:.....	5
1.1.6	Тусгай зөвшөөрлийн төрөл.....	5
1.1.7	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	5
1.2	Өөрийн ерөнхий мэдээлэл.....	5
1.2.1	Төсөл хэрэгжих талбайн байршил	6
1.3	Урьд оны олборлолтын нийт хэмжээ	7
1.4	Уурхайн хүчин чадал.....	7
1.5	Уулын ажлын төлөвлөгөө.....	8
1.6	Төслийн үйл ажиллагааны чиглэл	8
1.6.1	Уурхайн бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалт.....	8
1	Уурхайн цахилгаан хангамж	9
1.6.2	Уурхайн дулаан ба усан хангамж.....	9
2	Төслийн талбай, түүний Байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт	10
3	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	13
3.1	Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллүүд	17
3.2	Агаар орчныг хамгаалах төлөвлөгөө	17
3.3	Усан орчин хамгаалах арга хэмжээ	18
3.4	Хөрсний эвдрэл, бохирдол, хамгаалах төлөвлөгөө	18
4	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20
4.1	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	20
4.2	Хөрсөн болон ургамлан бүрхэвчид нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	22



4.3	Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	24
4.4	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	26
4.5	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	28
4.6	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	29
4.7	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	29
4.8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	29
4.9	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	33
4.10	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	37
4.11	Олон нийтэд тайлагнах.....	38
4.12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт.....	39
4.13	Мониторингийн шинжилгээ.....	41
5	Хавсралт материал.....	44

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1.	Төсөл хэрэгжих талбайн захын цэгүүд солбилцол.....	6
Хүснэгт 2.	Уурхайн ажиллах горим	7
Хүснэгт 3-1.	Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр	14
Хүснэгт 4-1.	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	20
Хүснэгт 4-2.	Хөрсөн болон ургамлан бүрхэвчид нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	23
Хүснэгт 4-3.	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний биелэлт.....	25
Хүснэгт 4-4.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	28
Хүснэгт 4-5.	Дүйцүүлэн хамгаалах талбайн байршил	28
Хүснэгт 4-6.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	29
Хүснэгт 4-7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хог хаясан газрыг түрж цэвэрлэсэн	30
Хүснэгт 4-8.	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	33



Зургийн жагсаалт

Зураг 1-1. Төслийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайн байршил (M1:100000 байрзүйн зураг дээр , L-48-96).....	6
Зураг 4-1. Салхи ихтэй өдөр болон тоосжилт ихээр үүсэх хэсэгт автомашинд бүтээлгэ хучлага хучиж байсан.....	21
Зураг 4-2. Гол тогоо болон ОО өрөө, Усанд орох газрын байнгын ариутгал хийж, Зарим ариутгалын бодисыг бэлэн байлгаж байсан.....	23
Зураг 4-3. Авто машины гаралтай хог хаягдлыг нэгдсэн нэг цэгт цуглуулж хөрс бохирдохоос сэргийлж байсан.....	24
Зураг 4-4. Хуурай сайр болон талбай орчим цэвэрлэгээ хийсэн.....	26
Зураг 4-5 Амрах талбайн ногоон байгууламж.....	27
Зураг 4-6 Тэрбум мод хөтөлбөр төслийн хүрээнд худалдаж авсан мод.....	27
Зураг 4-7. 7-14 хоног болон ариутгал, халдваргүйжүүлэлт хийгдэж байсан.....	30
Зураг 4-8. Ажил эхлэхээс өмнө сургалт зохион байгуулсан.....	34
Зураг 4-9. Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангаж ажилласан, сургалт зохион байгуулсан.....	34
Зураг 4-10. Цугларах цэг байгуулж. Кемпийн ойр орчимд хамгаалалтын шон сулгасан.....	35
Зураг 4-11. Хөдөлмөр хамгааллын самбар байршуулж. Бүх газар галын хор авч тавьсан.....	35
Зураг 4-12. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	38



1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр

“Болор Жонш” ХХК

Регистрийн дугаар: 2830701

Улсын бүртгэлийн дугаар: 811002022

1.1.1 Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:

Уул уурхай

1.1.2 Төслийн нэр

“Зүүн Арагтайнн хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах” төсөл

1.1.3 Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг:

Дундговь аймгийн Баянжаргалан сум, Баянхошуу, Сумын төвд-00

1.1.4 Захирлын нэр, утас:

Захирал: SIRENGULENG утас 88991661

1.1.5 Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:

Байгаль орчны мэргэжилтэн А.Салтанат 99415161

1.1.6 Тусгай зөвшөөрлийн төрөл

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл

Дугаар: 11820А

Хүчинтэй хугацаа : 30 жил

1.1.7 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд

2021 оны 4-р сар Монгол улсын Байгаль орчин аялал жуулчлалын яам

1.2 Өнөөгийн ерөнхий мэдээлэл

“Болоржонш” ХХК нь “Зүүн Аргатай”-н ордын 33 га талбайд хайгуулын 6628Х тоот тусгай зөвшөөрлийг авсны үндсэн дээр 2005-2006 онд өөрийн хөрөнгөөр хайгуулын ажлыг хийж, хайлуур жоншны нөөц тоохон үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд уг хурлаас “Хайгуулын ажлыг гүйцээн нарийвчилж, нөөцийг бодитой (В) зэргээр тооцоолох” шийдвэр гарсны дагуу 2009-2011 онуудад нэмэлт хайгуулын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 2006 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар /хуучин нэрээр/-ын ГУУКА-аас ашиглалтын 11820А тоот лицензийг авсан

байна. Болоржонш ХХК нь 11820А тоот бүхий ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн дагуу “Зүүн-Аргатай” хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглахаар төлөвлөж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн хэмжээ 33.49га бөгөөд “Зүүн-Аргатай” хайлуур жоншны ордын геологийн бодит (В) нөөц 448604.67тн, үйлдвэрийн нөөц нь 460659.34тн байна. Хайлуур жоншны ордыг гадаад болон дотоод овоолго бүхий автотээвэртэй ашиглалтын системээр гидравлик экскаватор-өөрөө буулгагч автосамосвалын хослолыг хэрэглэн ашиглалт явуулахаар төлөвлөсөн.


1.2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил

Болоржонш ХХК-ийн Зүүн Аргатай хайлуур жоншны орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт тал хээрийн болон говийн бүсийн заагт 33. 49 га талбайг эзлэн оршино. Уг орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 250 км, төмөр замын Чойр өртөөнөөс баруун урагш 100 км зайд оршино.

Хүснэгт 1-1. Төсөл хэрэгжих талбайн захын цэгүүд солбилцол

#	Уртраг	Өргөрөг
1	45° 33' 51.61"	107° 57' 31.51"
2	45° 34' 16.61"	107° 57' 31.51"
3	45° 34' 16.61"	107° 57' 51.51"
4	45° 33' 51.61"	107° 57' 51.51"

Зураг 1-1. Төслийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайн байршил (М1:100000 байрзүйн зураг дээр , L-48-96)



1.3 Урьд оны олборлолтын нийт хэмжээ

2020-2022 онд COVID-19 улмаас үйл ажиллагаа явуулаагүй байна. 2023 оны 10-р сард хуучин олборлосон талбайгаас ядуу агууллагатай жонш баяжуулах руу зөөсөн. 980м3.

1.4 Уурхайн хүчин чадал

Зүүн-Аргатай ордыг “Болоржонш” ХХК нь 2017 оноос ашиглаж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар тусгай зөвшөөрлийн талбайн үлдэгдэл геологийн В+С ангилалаар 449777 т жоншны хүдэр буюу 249785.5 т хайлуур жоншны нөөц байна. Төслөөр ил уурхайн хүчин чадлыг жилд 81.0 мян.т хүдэр олборлохоор тусгасан бөгөөд ордын геологийн В зэрэглэлээр үнэлэгдээн нөөцийг 5.4 жилийн хугацаанд ашиглана.

Ил уурхай дулааны улирлын 200 хоногт 8 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжийн горимоор ажиллана. Уурхайд хөрс хуулалт, хүдэр олборлолтонд 1.0 м³ -ийн шанагатай ZX 450H маркийн экскаватор 1 ш, 20 т даацтай Nowo автосамосвал 7 ш, 3.0 м³ утгууртай дугуйт ачигч 2 ш, уулын үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд байна.

Баяжуулах үйлдвэр нь жилд 100.0 мян.т хүдэр баяжуулах хүчин чадалтай бөгөөд ил уурхайгаа олборлосон хүдрээс гадна ойр орчимд орших жоншны уурхайн бага агуулгатай хүдрийг авч баяжуулна.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

#	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга	Тайлбар
	Өвлийн улирлын сул зогсолт	хоног	151	11-р сарын 01-ээс 04-р сарын 01 хүртэл
	Уурхайн жилд ажиллах хоног	хоног	214	04-р сарын 04-ээс 11-р сарын 01 хүртэл
	Баяр ёслолын амралт	хоног	5	Хөдөлмөрийн тухай хуулийн 76.1.4, 76.1.5, 76.1.7-р зүйлийн дагуу
	Цаг агаарын саатал	хоног	7	-
	Засвар үйлчилгээ	хоног	7	Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус
	Жилд ажиллах бодит хоног	хоног	195	-
	Цаг ашиглалтын коэффициент	хоног	0,9	90%
	Хоногт ажиллах бодит цаг	цаг	14,4	Цаг ашиглалт тооцсон
	Жилд ажиллах бодит цаг	цаг	2808	Цаг ашиглалт тооцсон
	Уурхайн цагийн хүчин чадал	тн/цаг	8,19	Цаг ашиглалт тооцсон
	Уурхайн ээлжийн хүчин чадал	тн/ээлж	58,97	Ээлжинд 7,2 цаг ажиллана



Уурхайн хоногийн хүчин чадал	тн/хоног	117,95	Хоногт 8-н цагийн 2 ээлжээр
Уурхайн жилийн хүчин чадал	тн/жил	23000,0	Жилд ажиллах 195 хоног

Уурхайн жилийн бодит ажлын хоног 195 байна. Уурхайн хоногийн хүчин чадал нь 117.95 тн, ээлжийн хүчин чадал нь 58.97 тн, цагийн хүчин чадал нь 8.19 тн байхаар байна. Цаг ашиглалтын итгэлцүүрийг 0.9 байхаар тооцсон болно. Зүүн Аргатайинн хайлуур жоншны уурхай ашиглалтанд орсноор байнгын ажиллагсад 8, түр ажиллагсад 10 нийт 18-н ажлын байр шинээр бий болно. Ажилчдын тосгон 1 вагончик, 4 гэртэй байхаар төлөвлөж байна.

1.5 Уулын ажлын төлөвлөгөө

Зүүн-Аргатай жоншны орд газар “Болоржонш” ХХК 2017 оноос олборлолт явуулж байна. АМГ-ын ЭБМЗ-ийн 2013 оны 01-р сарын 23 -ны өдрйн ХХ-03-01 тоот дүгнэлтээр В+С зэргээр батлагдсан 468857.8 т хүдэр, 250447.9 т хайлуур жоншны(CaF₂) нөөцөөс 2017 -2018 онд 19080 т хүдэр, 662.4 т хайлуур жонш олборлож 2019 оны 01 -р сарын 01 -ний байдлаар ордын хэмжээнд боломжтой В зэрэглэлээр 429524 т хүдэр, 235233.7 т хайлуур жонш, С зэрэглэлээр 20253 т хүдэр, 14551.9 т хайлуур жонш, нийт 449777 т хүдэр, 249785.5 т хайлуур жонш байна. Үүнээс MV-011820 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 446872 т хүдэр, 247720.0 т хайлуур жонш байна.

1.6 Төслийн үйл ажиллагааны чиглэл

1.6.1 Уурхайн бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалт

Ил аргаар жонш олборлох “Зүүн-Аргатай” уурхай нь хүчин чадлын хувьд дунд зэргийн тул түүнийг ашиглахын тулд үйлдвэрийн үндсэн болон туслах томоохон объектуудыг барьж байгуулах шаардлагагүй байна. Уурхайн бүрэлдэхүүнд:

- Хөрс хуулах, жонш олборлох ил уурхай, хөрсний овоолго
- Жонш ангилан ялгах, боловсруулах төхөөрөмж түүний дэргэдэх хүдрийн овоолго
- Захиргаа, үйлчилгээний байрууд
- Цахилгаан хангамж / дизель станц /
- Ердийн галлагаатай ажилчдын байр
- Засварын газар /токарь/
- Хоолны газар /гэр/
- Тэсрэх материалын болон материалын агуулахууд
- Уурхай орчмын замууд (уурхайн эзэмшлийн талбайн хүрээнд орших) зэрэг объектууд багтана.



Төсөлд эдгээр аж ахуй, үйлдвэрлэлийн зориулалттай объектуудыг эсгий гэр болон чингэлгүүд ашиглана.

Ил уурхай. Уурхайн талбайг ашиглалтад бэлтгэх ажлууд (зам байгуулах, засах г.м) өрөмдлөг тэсэлгээ, хөрс хуулах, хүдэр олборлох болон хөрс, балансын бус хүдрийн овоолгууд байгуулах зэрэг ажлууд явагдана. Уурхайн нийт эзэмшлийн талбай нь 33.49 га бөгөөд энэ талбайн хүрээнд хүдэр ангилан ялгах, боловсруулах болон бусад туслах объектууд бүгд байршина.

Ил уурхайн бүрэлдэхүүнд: Хөрс хуулалт хийн хүдэр олборлох уурхай Шимт хөрсний овоолго - Уурхайн дотоод зам, Өрөмдлөг тэсэлгээний ажилтай холбоотой ажилбарууд хамаарагдана.

Захиргаа үйлчилгээний газар. Захиргаа үйлчилгээний объектуудад уурхайн удирдлагуудын контор (ажлын өрөө), наряд - даалгавар авах өрөө, ажилчдын хувцас солих, усанд орох байр зэрэг газрууд орно. Эдгээр газруудыг өрөмдлөг тэсэлгээний ажлын аюулгүйн зөвшөөрөгдсөн бүсийн гадна сэндвичэн барилгууд, ажлын өрөө, засвар үйлчилгээ хийж болохуйц вагончикуудыг барьж байгуулна.

Орон сууц, ажилчдын тосгон. Уурхай байгуулах эхний үед ажилчдыг сэндвичэн барилгуудаар, уурхайгаас 400 м - ээс доошгүй зайд зориулалтын талбайд тосгоныг байрлуулна.

1 Уурхайн цахилгаан хангамж

Уурхайд эрчим хүч шаардах томоохон хэрэглэгч байхгүй тул хүдэр ангилан ялгах төхөөрөмж, орон сууц болон бусад объектуудыг гэрэлтүүлэх, засварын газрын зарим цахилгаан тоног төхөөрөмж /токарийн машин, цахилгаан өрөм, гагнуурын аппарат г.м/ зэргийг ажиллуулахад зориулж ДЭС-100 цахилгаан үүсгүүрийг ашиглана.

1.6.2 Уурхайн дулаан ба усан хангамж

Уурхайн жилийн ажлын үргэлжлэх хугацаа 214 хоног тул хүмүүсийн оршин суух байр болон засварын зориулалттай вагончик зэргийг ердийн галлагаагаар дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.

Үйлдвэрлэлийн усны хувьд уулс хоорондын хотгорт гаргасан олон тооны худгууд тэдгээрийн үзүүлэлтүүд нь хангалттай бөгөөд зөвхөн 1-2 худаг д хангах бололцоотой юм

2 Төслийн талбай, түүний Байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт

Физик газарзүйн нөхцөл: “Болоржонш” ХХК -ийн “Зүүн-Аргатай” хайлуур жоншны орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн урагш 250 км, төмөр замын Чойр өртөөнөөс баруун урагш 100 км зайд оршино. Ашигт малтмал ашиглах MV-011820 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ нь 33 гектар юм.



Газрын гадаргуу: Гадаргуугийн хувьд далайн түвшингээс дээш 1100-1200 м өргөгдсөн жижиг толгод гүвээ хэлбэрийн мөлгөржсөн хэсэгт багтан, Хэнтийн нурууны төгсгөл, говийн бүсийн эхлэлийн зааг бүс хэсэгт оршдог. Хамгийн өндөр цэгүүд нь далайн түвшингээс дээш 1305-1320 м -т өргөгдсөн товгор уулс бөгөөд тэдгээр нь харьцангуй залуу гүний чулуулгаас тогтох учир барзгар гадаргуутай, эргэн тойрон 20-50 км зайд харагдалт сайтай байдаг. Урагшлах тутам газрын гадаргуу намсч, мөлгөржин жижиг гүвээ, толгод болон хувирдаг ба харьцангуй өндөржилт нь 10-50 м -ээс хэтэрдэггүй.

Ус зүй: Тухайн районы нэг онцлог нь тогтмол урсацтай гол горхи байдаггүй, зөвхөн Аргатай, Элгэн, Гашуун хар, Хужирт зэрэг жижиг булгуудтай, харин уужим хөндийнүүддээ хужиртай жижиг шанд тойрмууд нилээд элбэг байдаг. Хөндий амууддаа худаг элбэг, тэдгээрийн дебит нь 200-1600 л/цагт хэлбэлздэг боловч ихэнх усны чанар нь ундааны усанд тохиромж муутай байдаг.

Цаг уур: Тухайн район нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, улиралын ба хоногийн температурын хэлбэлзэл ихтэй, хур тунадас багатай хуурай агаартай, цаг агаарын олон жилийн ажиглалтын (1938-1998 он) дунджаар хамгийн хүйтэн 12, 1 -р сард болдог ба -23 ~ -24°С, хамгийн халуун үе 6 -аас 8 -р сард болдог бөгөөд +25 ~ +30°С орчим болдог.

Жилийн дундаж хур тунадас 113 мм ба үүний дийлэнх хэсэг нь 6 -аас 9 -р сард (90 мм) бороо хэлбэрээр буудаг байна. Салхи гол төлөв баруун хойноос зүүн ургаш чиглэлтэй, салхины жилийн дундаж хурд 4.7 м/сек гэх боловч хавартаа 15-20 м/сек хүрэх тохиолдол элбэг байдаг.

Хөрс, ургамал: Шимт хөрсний зузаан 5-20 см, цөөн тохиолдолд 40 см (нуур орчим) хүрдэг, хүрэн, бор өнгөтэй, ургамалын бүрхэвч сийрэг, түүний төрөл цөөн, голдуу таана, хүмүүл, агь, божмог, шарилж, зангуу ургадаг, харин нуур тойрмоо дагаж бага хэмжээгээр нугын янз бүрийн ургамал ургана. Модгүй, жалга, нугачаа дагаж, цөөн тоогоор хайлаас, тоорой энд тэнд ургасан байдаг, Мөн бага тархацтай, буйлс, дэрс, харгана, тоорой ургасан нь тохиолдоно.



Ан амьтан: Амьтны ертөнц нилээд олон төрөлтэй, араатан амьтдаас үнэг, чоно, мануул, хярс, дорго элбэг. Харин уулархаг хэсэгтээ цөөн тоогоор аргаль, янгир, тал хэсэгтээ нилээд олноор зээр, хар сүүлт тохиолдоно. Жигүүртний аймгийн төлөөлөгчид хамгийн элбэг: бүргэд, харцага, тоодог, тогоруу, ногтруу, болон бусад жижиг шувууд олон байдаг. Хавар, намартаа хачиг ихтэй, зун, намартаа царцаа, голио, гүрвэл, дэлэнч их хэмжээгээр байдаг, хортой могой элбэг тул болгоомжлох нь зүйтэй.

Хүн ам зүй, дэд бүтэц: Зам харгуйн хувьд орон нутгийн энгийн шороон замуудтай, хавь ойрын суурин газар, төвүүдийн хооронд шууд холбогдсон байдаг. Талбайн аль ч хэсгээр жилийн ямар ч улиралд явах боломжтой, харин томоохон хөндийнүүд нь зуны бороотой үед хужиртай тойром, намагтай болдог тул тэр болгон зам харгуйн хэсгээр туулах боломж муу байдаг.

Хүн ам цөөнтэй, гол төлөв малчид нүүдэллэн амьдардаг, 1км² талбайд 0.2-0.6 хүн ноогддог, хүн ам арай шигүү сууршилттай нь Говь-Угтаал, Баянжаргалан сумын төв, Морьт, Хонгор, Энгэр-Усны багийн төвүүд юм. Тэнд сургууль, цэцэрлэг, холбоо, эмнэлэг, дизель станц, дэлгүүр, худалдаатай. Сүүлийн үед Бумбат, Сүүл өндөр, Зүүн, Баруун цагаан овоо, Хавиргад



БОЛОРЖОНШ ХХК

“Болор жонш” ХХК-ий Зүүн аргатай уурхайн төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт

жоншны жижиг уурхайнууд ажиллаж эхэлж байна. Талбайн орчинд өндөр хүчдэлийн шугам байхгүй, Улаанбаатараас 250 км, Чойр хотоос 100 км зайд тусгай зөвшөөрлийн талбай оршдог ба ойр орчны уурхайнууд нь эрчим хүчээ дизель станц ажиллуулж гаргаж авдаг



3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн явцад агаарын бохирдол нэмэгдэх, хөрс элэгдэх, ургамлан бүрхэвч талхлагдах, ан амьтад үргэн дайжих, дуу чимээг орчиндоо ихээр үүсгэх, хог хаягдал ялгаруулах зэрэг гол сөрөг нөлөөлөл багагүй учрах болно. Эдгээрийн үр нөлөө нь төсөл хэрэгжих явцад их боловч нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээлтийг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх, байгаль хамгаалах төлөвлөгөөг сайтар гүйцэтгэн цаашид хяналт шинжилгээний хөтөлбөрийг зөвлөмжийн дагуу цаг тухайд хийж хэвшвэл гол сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой гэж байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгасан.

Төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа хийсэн мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь газрын гадарга, агаар, хөрс, ургамал, газрын гүний ус, амьтан юм.

Зүүн аргатайн хайлуур жонш олборлох ил уурхайн төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн хэрэгжилтийн байдал болон орчны байдалтай танилцаж холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо **магадлан жагсаах** аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 3-1. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлтүүд	Өүеяүд			Õóããöàà		Ýðäýëò		Ýд÷èì		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино	Урт хугацааны	Буцаж	Буцалтгүй нөлөөлөл	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1.Байгалийн экосистемийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Гадаргын усны урсацын өөрчлөлт										
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x			x	x		
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x	x		
Зэрлэг амьтдын орон зай			x	x		x				x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x		x		x				x
2.Байгаль орчны чанарын өөрчлөлт										
Газрын доорхи усны чанарын өөрчлөлт		x				x			x	
Гадаргын усны чанарын өөрчлөлт		x		x		x				x
Агаарын бохирдол	x			x			x		x	
Хөрсний бохирдол		x			x	x				x
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		x		x		x				x
Дуу чимээ, шуугианы нөлөө	x			x			x			x
3.Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x				x		x	x		
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x	x		
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										

Байгаль орчны үзүүлэлтүүд	Өүеáýð			Õóááõáá		Ýðáýёò		Ýð-è ì		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино	Урт хугацааны	Буцаж	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										
4.Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+				+	+			+	
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+	+			+	
Бүтээн байгуулалтад дэмжлэг болох	+				+		+		+	
Ажлын байр нэмэгдэх	+				+	+			+	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх		+		+			+			+
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		+		+		+				+
5.Бусад нөлөөлөл										
Уурхайн î ñî ё, аваар		x					x		x	
Ахуйн болон үйлдвэрийн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтны усыг бохирдуулах.		x		x			x			x
Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гаргах, шавьж үржих		x		x		x				x
Хүчтэй салхи, үерсээí àр óө		x		x		x			x	
Дүн	11	11	1	12	9	12	11	5	10	8

Энэхүү нөлөөлөлд ахуйн хог хаягдлыг ариутгал хийгээгүйгээс хүн амын эрүүл мэндэд эргэж муугаар нөлөөлөх, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлнө.

Нөлөөллийн эрчим

Болзошгүй нөлөөллийн ихэнх нь сулавтар (8), дунд (7), их (5) зэрэгт хамаарч байна. Харин хөрсний элэгдэл бохирдолд нилээд хүчтэй нөлөөлөхөөр байна. Иймээс хөрсийг хамгаалах асуудал чухал болохыг харуулж байна

3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллүүд

3.2 Агаар орчныг хамгаалах төлөвлөгөө

Хүдэр ачих, буулгах ажлын үед:

- Хүдэр ачих, буулгах үед ажлын талбай орчимд их хэмжээний тоос үүсэхээс гадна агаар орчинг бохирдуулдаг. Иймд зам талбайг услах, тоос дарах арга хэмжээнүүдийг авах.
- Зам талбайг байнга тэгшилж, бульдозер болон автогрейдерээр сул шороог хусч зайлуулах
- Хүчтэй салхи шуургатай үед газар шорооны ажлыг хязгаарлах, хийхгүй байх
- Эвдрэлд орсон газрын боломжтой хэсгийг нь тухай бүрт нь үржил шимт хөрсөөр бүрхэж ургамалжуулах.

Тээвэрлэлтийн үед:

- Хүдэр, хөрс болон баяжмал тээвэрлэх үед тухайн орчинд маш их тоос тархах тул автозамыг услах, сул шороо, чулууг хусч зайлуулах, зам хатууруулагч тусгай зориулалтын бодис ашиглах,
- Тоос шороог багасгахад услах болон тоос дарах зориулалтын уусмалыг ашиглах,
- Тээвэрлэлтийн замын сүлжээг сайтар төлөвлөх, зөвхөн батлагдсан замын сүлжээг ашиглах, олон салаа зам гаргахгүй байх, замын тэмдэглэгээ хийх, сайжруулах,
- Үйлдвэрт ажиллах тоног төхөөрөмжүүдийн хөдөлгүүрээс гарах хорт хийг хүлцэх хэмжээнд байлгахад техникийн бүрэн бүтэн байдал чухал байдаг. Иймд техник, тоног төхөөрөмжийг тогтмол үзлэг оношлогоонд оруулах, засвар үйлчилгээг байнга хийж хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлагад нийцүүлэх,

Нөлөөллийн товч тодорхойлолт: Салхи шуурга ихтэй үед ордын ашиглалтын талбайгаас тоос босч орчны агаарт бохирдол үүсгэнэ. Хөрсний чийг бага, салхины хурд их байх үед агаар дахь тоосны хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх үндэслэлтэй.

3.3 Усан орчин хамгаалах арга хэмжээ

Нөлөөллийн товч тодорхойлолт: Тус унд ахуй болон технологийн хэрэглээний усыг Баяжуулах үйлдвэрт гаргасан 3 худгаас ашиглана.

Нөлөөлөлд өртөх объект: Гүний ус /хөрсний ус/

Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Үйлдвэрийн хэрэглээний усны буцаан авах, дахин ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэх, усыг дахин хэрэглэх, эргэлтэнд оруулах, урсгал сөргөн буцаан ашиглах зэргээр усны хэрэглээг хэмнэх арга хэмжээг авах шаардлагатай.
- Ахуйн хэрэгцээнээс гарах хаягдал усыг цэвэршүүлэн MNS 4943 : 2011 “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага” стандартын түвшин хүртэл цэвэршүүлэн зам талбайн тоосжилтыг дарахад эргүүлэн ашиглах
- Хэрэглээний усны салаалсан хоолойнуудад усны тоолуур суурилуулж, усны хэрэглээг хэмжиж, хянаж, үргүй зардлыг багасгах
- Үйл ажиллагааны түвшинг дээшлүүлж, үр дүнтэй удирдлагын аргачлал болоод стандартыг боловсруулан, зураг төслийн шаардлагын дагуу усны хэрэглээнд хяналт тавьж, төсөвлөсөн зарцуулалтын хэмжээнд барих зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх
- Ус дамжуулах шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг хангаж байнгын хяналт тавих
- Бохир ус цэвэршүүлэлтийн технологид хяналт тавьж стандарт, нормын хэмжээнд хүрч ажиллах
- Ашиглаж байгаа усны жилийн хэмжээг багасгахын тулд орчин үеийн дэвшилтэт техник технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, ус эргүүлэн ашиглах системийн ашигт үйлийн коэффициентийг нэмэгдүүлэх
- Гадаргын болон хөрсний уснаас үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглахыг хориглох

Гүний усны нөөц, чанарт байнгын хяналт тавьж, үйлдвэрлэлийн хэрэгцээнд зарцуулагдаж байгаа усны хэмжээг гүний усны нөөцийн 3/1-ээс хэтрүүлэн ашиглахыг хатуу хориглох зэрэг арга хэмжээг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай

3.4 Хөрсний эвдрэл, бохирдол, хамгаалах төлөвлөгөө

Нөлөөллийн товч тодорхойлолт: Ордын ашиглалтын үйл ажиллагааны улмаас хөрсний бүтэц өөрчлөгдөж, үржил шим бууран хөрс эвдрэлд орох, хатуу шингэн хог хаягдлаар хөрс бохирдох нөхцөл бүрдэнэ.

Нөлөөлөлд өртөх объект:

Баяжуулах үйлдвэрийн талбайн хөрс бүхэлдээ шууд нөлөөлөлд өртөнө.

Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Ордын ашиглалтын үеийн агаарын бохирдол нь олборлолт, тээвэрлэлтийн үеийн үйл ажиллагааны явцад голчлон гарна. Иймд маркшейдерийн орд ашиглалтын талбайн зураг дээр салхины зонхилох чиглэл, гадаргын рельеф нөхцөлтэй уялдуулан овоолго болон ажилчдын сууц, хөрс хуулалт, олборлолтын эхлэх, тээвэрлэлтийн замын сүлжээг хаагуур байхыг маш тодорхой гаргаж өгөх хэрэгтэй.
- Овоолгыг тойруулан үер, уснаас хамгаалах далан шуудуу байгуулах
- Тээвэрлэлтийн явцад машин, техникийн даацыг хэтрүүлэхгүй байх.
- Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрч доройтсон газрууд болон хаягдал овоолгын огцом налуу хажууг сайтар хэлбэршүүлэн засч техникийн нөхөн сэргээлтийг чанартай хийсний дараа шимт хөрсөөр хучна. Үүний дараа биологийн нөхөн сэргээлтийн ажлаар олон наст өвслөг болон буурцагт ургамал тариалж талбайг хөрсжүүлж, ургамлан нөмрөгтэй болгох ажлууд хийх
- Олон салаа зам гаргахгүй байхаас гадна ашиглалтанд өртөхгүй талбайг эвдрэлд оруулахгүй байхад анхаарах
- Тээвэрлэлтийн замыг эмх цэгцтэй зохион байгуулж тогтсон маршрутаар явах.
- Шатахуун хадгалах сав, дотоод шаталтын хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл, машин механизмуудаас ажлын үед гарах шатах тослох материалын агаар дахь ууршилт, ахуйн хэрэглээний зуухны галлагаанаас гарах хийн хольцын хэмжээг зөвшөөрөх дээд хэмжээнээс бага байлгахад технологийн хувьд зөв сонголт бүхий техник хэрэгсэл ажиллуулах, засвар үйлчилгээг чанартай хийх, утаа багатай зуух ашиглах
- Уурхайн хүрээнд ажиллах машин механизмын янданд шүүлтүүр тавих арга хэмжээг авах.
- Ордын ашиглалтын үеийн агаарын бохирдол нь хөрс хуулалт, тэсэлгээ, олборлолт, тээвэрлэлтийн үеийн үйл ажиллагааны явцад голчлон гарна. Иймд тухайн газруудыг их салхи шуургатай болон орчны цаг агаарын 5 хоногийн цаг агаарын мэдээнд үндэслэн чийгшүүлж байх.

4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

4.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Төслийн хүрээнд 2020 онд барилгын ажил эхлэснээс хойш агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээ.

- Тээврийн замыг, Сумын тогтоолд заасан зургийг үндэслэн хийж гүйцэтгэсэн бөгөөд тоосжилт багасгах үүднээс түр замын нийт уртад тоосжилт үүсэх хөрсийг хуулж нэгдсэн нэг замтай болгосон гүйцэтгэсэн.
- Гүйцэтгэгч компаниуд өөрсдийн эзэмшлийн автомашинуудад бүтээлэг авч, тоосжилт их үед бүтээлгийг ашиглан тоос босохоос сэргийлж байсан.
- Ажилчдын түр байр буюу кемпийн урд тал, авто зогсоолд өдөрт нэг удаа талбайн усалгааг хийж гүйцэтгэж байсан.
- Автомашинуудыг цаг тухай бүрт нь засвар үйлчилгээг хийж, шаардлагатай тохиолдолд оношлогоо хийлгэн бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан

Хүснэгт 4-1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын зардал
Жонш олборлолтын үйл ажиллагаанаас уурхайн карьер орчимд тоосжилт үүсэх	Газар шорооны ажлын улмаас шороо тоос босгохгүйн тулд замын гадаргуу, уурхайн эдэлбэр газар зэргийг чийгшүүлэх арга хэмжээг орчны цаг агаарын 5 хоногийн цаг агаарын мэдээнд үндэслэн байнга явуулах;	Уурхайн ашиглалтын хугацаанд хүдэр буулгах талбайг цэвэрлэж тоосжилт үүсэхгүй өдөр ачиж буулгах ажил хийгдсэн:
Жонш ялгах үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх	Салхи багатай өдөр цагийг үр бүтээлтэй ашиглах	
Жонш тээвэрлэх үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх	Тоос үүсгэх материалыг тээврийн хэрэгслээс буулгах өндрийг багасгах	
Жонш тээвэрлэх үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх	Агаарын чанарын иж бүрэн багаж суурилуулах	2023 оны төлөвлөгөөний дагуу уулын ажил хийгдээгүй.
	Орчны тоосжилт болон салхины хурд, дуу чимээг бууруулах болон салхинаас хамгаалах зорилгоор мод бут тарих	2023 он 5-р сард 300 ширхэг мод тарьсан
Хүнд даацын машин тэрэгнээс хийн ялгарал үүсэх	Операторууд машин, механизмын янданд утаа шүүгч суурилуулах. Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрүүдийн тохиргоо, оншилгоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх.	Тээвэр хийж буй авто машины ачааг хучилгаар хучих ажлыг зохион байгуулсан. 2023 оны оншилгоонд оруулсан
	Тоосжилт үүсгэх шороон зам болон ажлын талбайг усалж чийгшүүлэх	Хүдэр тээвэрлэлтийн үед тоосжилт ихээр үүсэх хэсэгт усалгаа хийгдсэн.

Зураг 4-1. Салхи ихтэй өдөр болон тоосжилт ихээр үүсэх хэсэгт автомашинд бүтээлгэ хучлага хучиж байсан.



4.2 Хөрсөн болон ургамлан бүрхэвчид нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Төслийн хүрээнд 2023 онд Уурхай орчим хөрсөн болон ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээ.

- Зүүн Аргатайн хайлуур жоншны ордод олборлолтын эхний шатанд үржил шимт хөрсний овоолгын байршлыг зонхилох салхины дор, хур борооны усанд угаагдахааргүй газар байрлуулж, овоолгын гадаргууг ургамалжуулах шаардлагатай
- Шатах тослох материал хадгалах, засвар хийх талбайг үер, галын аюулд өртөхөөргүй газарт сонгон байрлуулж, санамсаргүй тохиолдлоор асгарахаас урьдчилан сэргийлж элс хайрган хучилт хийж, тусгай тэмдэг тэмдэглэгээг байрлуулах.
- Нефтийн бүтээгдэхүүн нь органик нэгдлүүдийн нийлмэл бөгөөд хөрсөнд нэвчсэн тохиолдолд түүний гүнд ихээхэн хэмжээний бохирдлыг бий болгон удаан хугацаагаар хадгалагддаг онцлогтой. Ингэж бохирдсон хөрсийг хуулан авч тусгаарлагч гадаргуу дээр овоолон 18-20%-ийн хлораминий уусмалаар бороожуулан ариутгаж, нефтийн бүтээгдэхүүний агуулга 0.07 мг/кг-аас ихгүй, 4 этилт хар тугалганы хэмжээ 0.05 мг/кг-аас ихгүй нөхцөлд буцаан байршуулж болно.
- Автомашин явах зам, зогсох талбайг нарийн тогтоож тэмдэгжүүлэхийн дээр олон салаа зам үүсэхээс сэргийлж уурхай орчмын замын сүлжээг оновчтой зохион байгуулах
- Хөрсний хяналтын цэг дээр хяналт шинжилгээг тогтмол хийх.
- Хөрсөнд хор нөлөө үзүүлэхгүй био ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлэх
- Уурхайгаас боловсруулах үйлдвэр хүртэл нийт 3.3 км орон нутгийн замыг сайжруулж хайрган хучилттай зам болгох
- Гүйцэтгэгч ШТМ асгарахаас сэргийлж, модны үртэс, элстэй шуудай авч бэлэн байлгаж байгаа бөгөөд асгаралт үүссэн үед хөрсийг хуулан авч бохирдолтой хөрсийг гялгар уутанд хийж хадгалж байна.
- ШТМ-аар хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж Шатахуун хадаглаж буй савыг доод талд, ойр орчимд хайрга дэвсэж доошоо нэвтрэхээс сэргийлж байгаа.
- Кемп болон ажлын талбар хооронд зорчих нэг замтай болгож хөрс талхагдахаас сэргийлж байна.
- Кемпийн ОО болон бусад талбайд байнгын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийж байсан.


Хүснэгт 4-2. Хөрсөн болон ургамлан бүрхэвчид нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба зардал /төгрөг	2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын зардал
Ногоон байгууламж байгуулах /эдэлбэр газрын 20%-иас доошгүй талбайд/	Үйлдвэрийн талбайд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан зардал	Ашиглахгүй талбайнуудыг цэвэрлэж, Бага агуулга овоолсон талбайг зөөвөрлөж талбайг тэгшилсэн.
Тээвэрт ашиглах хүнд даацын машин техникийн дотоод болон гадаад замыг тогтоосон маршрутаар явуулах. Салаа зам гаргахаас сэргийлж тэмдэг тэмдэглэгээ нэмж байршуулах	Үйлдвэрийн хашаанд	200,000	Тэмдэг тэмдэглэгээ авч тавьсан. 500,000
Шатах тослох материал асгаруулж болохгүй хөрс, ургамал зэргийг хамгаалах сурталчилгааны самбарууд байгуулах, ШТМ-аар бохирдсон хөрсийг тээвэрлэн цуглуулах талбайд тээвэрлэн хүргэж саармагжуулах	Машины зогсоол, машин тэрэг зорчих хэсэг	600,000	Зогсоолын орчим элс тавьсан бөгөөд хэрэв тухайн зогсоолд байгаа машинаас ШТМ асгарвал даруй шингээж авч саармагжуулах арга хэмжээг авна.
Авто зогсоол болон бусад газар автомашинаас шатахуун болон бусад тос тослох материалын асгаралт үүсэж хөрсөнд нэвчихээс сэргийлж байнгын хяналт тавих,	Төслийн талбай	300,000	Энэ жил сумын нэгдсэн хогын цэгийг түрж задгай хог хаягдлыг булж өгсөн. 600,000.
Хог хаягдлыг тогтмол хугацаанд хогийн цэгт зайлуулах сумтай хамтран ажиллах		Хог хаягдлын менежментийн зардлаар	
Барилгын ажлын үед энгийн нүхэн жорлон ашиглахгүй ба байгальд ээлтэй технологи бүхий био жорлонтой байна.	Ажилчдын түр суурин	дотоод зардал	Баяжуулах үйлдвэрийн кемпийн талбайд хог хаягдлын цэг байгуулсан.
		1,650,000	1,100,000

Зураг 4-2. Гол тогоо болон ОО өрөө, Усанд орох газрын байнгын ариутгал хийж, Зарим ариутгалын бодисыг бэлэн байлгаж байсан.



Зураг 4-3. Авто машины гаралтай хог хаягдлыг нэгдсэн нэг цэгт цуглуулж хөрс бохирдохоос сэргийлж байсан.



4.3 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Нөлөөллийн товч тодорхойлолт: Тус уурхай унд ахуй болон замын тоосжилт дарах зорилгоор 107° 57' 31.51" 45° 33' 51.61" орших гүний худгаас ус ашиглана.

Нөлөөлөлд өртөх объект: Гүний ус /хөрсний ус/

Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Ахуйн хог хаягдлыг хаях төвлөрсөн нэг цэгтэй байх
- Талбайд байнгын цэвэрлэгээ хийж байх
- Хатуу хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулж байх
- Усыг ариг гамтай ашиглах
- Ус ашиглах гэрээ байгуулах

Гүний усны нөөц хомстохоос урьдчилан сэргийлж ус хэмнэх дараах арга хэмжээг төлөвлөх хэрэгтэй. Үүнд:

1. Ахуйн хэрэгцээнээс гарах хаягдал усыг хог хаягдлын менежментэд тусгасан зөвлөмжийн дагуу цэвэршүүлэн MNS 4943 : 2011 “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага” стандартын түвшин хүртэл цэвэршүүлэн зам талбайн тоосжилтыг дарахад эргүүлэн ашиглах
2. Ус ашиглах дүгнэлтийг эрх бүхий байгууллагаар гаргуулж, усны хэрэглээ, эх үүсвэрийг тодорхойлж өгөх.
3. Усыг ариг гамтай хэрэглэх, зарцуулах тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх

4. Технологийн /зам талбайг чийгшүүлэх болон бусад/ хэрэгцээний усыг гүний худгаас хангах бөгөөд тухайн худгийг тоолууржуулж технологийн зориулалтаар ус ашигласны төлбөрийг орон нутагт тогтмол төлж байх шаардлагатай.
 5. Гүний усны нөөц, түвшинг хянах зориулалт бүхий мониторингийн цооног байгуулах
 6. Гадаргын болон хөрсний уснаас уурхайн үйл ажиллагаанд ашиглахыг хориглох
- Гүний усны нөөц, чанарт байнгын хяналт тавьж, уурхайн хэрэгцээнд зарцуулагдаж байгаа усны хэмжээг гүний усны нөөцийн 3/1-ээс хэтрүүлэн ашиглахыг хатуу хориглох зэрэг арга хэмжээг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай

Хүснэгт 4-3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний биелэлт

Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба зардал/төгрөг/	2023 оны хэрэгжилт
Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно. Үйлдвэрийн ажлын талбай, ажлын байранд янз бүрийн материал эдлэхүүн, тоног төхөөрөмжийг холбогдох норм дүрэм, стандартад заасны дагуу хадгалж, байрлуулах;	400,000	Үйлдвэрийн бүсэд үерийн усны хамгаалалтын бүс тогтоосон ялангуяа хаягдлын сан орчим
Гүний ус, байгаль орчинг бохирдуулахгүй байх анхааруулга, санамж бүхий самбар хийх	450,000	Самбар хийж тавьсан . 300,000
Үйлдвэрийн ажилд шаардлагатай цэвэр усыг зөвшөөрөлтэй худаг, уст цэгүүдээс авч ашиглах, зөвшөөрөлгүй худаг гаргаж ус худаг гаргах, суваг шуудуу татахыг хориглоно		Шаардлагатай зөвшөөрөл бүгдийн авсан. Гаргасан худаг болгон дээр Паспорт авч Сав газрын захиргаанд бүртгүүлсэн.
Усны зарцуулалтын мэдээ тайлан гаргаж, зохистой зарцуулалтыг хянах.	Төслийн өдөр тутмын үйл ажиллагааны зардал	
Ус ашигласны төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах,	Усны тоолуурын заалтаар тооцож төлөх	
Төслийн талбайд үерийн далан шуудууг стандартын дагуу зөв байгуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд	Уурхайн орчмын хог хаягдлыг байнга цэвэрлэж байгаа
Үерийн далан шуудуунд бөөгнөрсөн хогийг тогтмол цэвэрлэж байх	Ажилчдаар хийлгэх тул цалингийн сангаар	

Зураг 4-4. Хуурай сайр болон талбай орчим цэвэрлэгээ хийсэн.



4.4 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Баяжуулах үйлдвэрийн ажил нь 2021-2022 онд хүртэл уул уурхайн ажил явагдаагүй тул нөхөн сэргээлтийн төлөвлөсөн боловч COVID-19 улмаас зарим ажилчид цаг тухайд орж ирж чадаагүй.

Мөн 2023 онд баталсан уулын ажлын төлөвлөгөөны дагуу ажиллаж эхлээгүй бөгөөд 10-р сард уурхайн ажил эхэлсэн. Гэвч тухайн газарт Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 300 ширхэг мод тарьж, ажилчдын амрах байр орчим ногоон байгууламж бий болгосон.

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ
Биологийн нөхөн сэргээлт		
Уурхайн ашиглагдахгүй эвдэрсэн талбай, талхагдсан газрыг нөхөн сэргээх	Уурхайн талбайн талхлагдсан хэмжээнээс хамаараад 5-10 м радиус орших газарт биологийн нөхөн сэргээлт хийх. Ургамалжуулахдаа үржил шимт хөрсөөр 0.3 м зузаантай хучилт хийж олон наст ургамал тарьж, хөрсийг ширэгжүүлнэ. Мөн талхлагдсан газрыг хөрсийг сэргээж олон наст ургамал тарина	Ажилчдын кемп, Амрах талбай хэсэгт биологийн нөхөн сэргээлт хийж, шимт ногоон байгууламж бий болгосон.
Уурхайн кемпэп замын дагуу мод сөөг, тарир.цэцэрлэгжүүлэх	Ногоон байгууламжийг хур бороо орсны дараа байшин барилга, явган зорчигчийн хучаастай замаас аль болохоор их усыг ногоон байгууламжинд саадгүй урсан оруулахаар бодож зам талбайг барьж байгуулах, усалгааны системийг бий болгох, Ямар ч ургамалд газрын дээд хэсэгтэй тэнцүү хэмжээний үндэсний систем байдаг тул ургамал тарих зайг тохируулах	2023 оны 5-р сард Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд Уурхайд 300 ширхэг мод тарьсан.

Зураг 4-5 Амрах талбайн ногоон байгууламж



Зураг 4-6 Тэрбум мод хөтөлбөр төслийн хүрээнд худалдаж авсан мод



4.5 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн нөлөөлөлд өртсөн газрын хэмжээг тогтоосны дараагаар төслийн нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтоодог. Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтооход дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ. Амьдрах орчны төрөл; Экосистемийн ховор байдал; Экологийн эрүүл байдал; Ландшафтын байршил; Нөлөөллийн хугацаа.


“Болоржонш” ХХК-ийн хувьд 2023 онд **Аймаг, сумын ЗДТГ, тэдгээрийн асуудал хариуцсан байгууллага, орон нутгийн оролцогч талууд, төсөл хэрэгжүүлэгч зэрэг талуудтай** зөвшилцсөны дараа дүйцүүлэн хамгаалахаар сонгогдсон газарт газар төлөвлөлт, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ, биотехникийн арга хэмжээний судалгаа зэрэг ажлууд нэмэлтээр хийгдэхээр байгаа. Энэ жил дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээнд Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийнэ.

Хүснэгт 4-4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал /Мян.төг/	Хэрэгжүүлэлт
1.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тусгах ба дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь Баяжуулах үйлдвэрийн талбайн хэмжээтэй ижил хэмжээтэй байна.	2023 онд	2,500	Орон нутгийн байгаль орчны газарт очиж уулзсан бөгөөд дүйцүүлэн хийх боломжтой талбайнуудад Од динамик ХХК-аар БОСУ ажил хийлгүүлсэн

“Болоржонш” ХХК “Зүүн аргатай хайлуур жоншны ордыг ашиглах” төслийн “Дүйцүүлэн хамгаалах талбайн Баянжаргалан сумын Аргатай баг Ястын уурхай газарт Уурхайлалтанд өртөж эзэнгүй үлдсэн талбайд дүйцүүлэн хамгаалах хийх боломжтой нэг хувилбар болгон судалсан..

Хүснэгт 4-5. Дүйцүүлэн хамгаалах талбайн байршил



4.6 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Болоржонш” ХХК-ий Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр үйл ажиллагааны явцад ямарч нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөхгүй болно.

4.7 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Болоржонш” ХХК-ий “Хайлуур жоншны баяжуулах үйлдвэрийн талбайн районд түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй болно.

4.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

